МЭДЭЭ · 2022 оны 12-р сарын 15

ПРОКУРОРЫН БАЙГУУЛЛАГА 355 ГОМДОЛ, ХҮСЭЛТИЙГ ШИЙДВЭРЛЭВ



Прокурорын байгууллага 2022 оны 12 дугаар сарын 05-наас 14-ний өдрүүдэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч иргэн, хуулийн этгээд болон өмгөөлөгчөөс гаргасан 362 гомдол, хүсэлтийг шинээр хүлээн авч, нийт 1130 гомдол, хүсэлтийг хянан шалгав. Үүнээс 355-г нь шийдвэрлэж холбогдох арга хэмжээг авсан бөгөөд одоо прокурорт 775 гомдол, хүсэлт хянагдаж байна.

Шинээр хүлээн авсан гомдол, хүсэлтийн 3 нь ял эдлүүлэх ажиллагаатай холбоотой, 2 нь шүүхээр шийдвэрлэгдсэн хэрэгт шинээр илэрсэн нөхцөл байдлыг шалгуулах, 10 нь зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаар байгаа бол 347 нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаар гаргасан гомдол, хүсэлт байна.

Дээрх хугацаанд Нийслэлийн Дүнжингарав, Мишээл төвүүдэд ажиллаж байгаа "Прокурорын байгууллагын нэг цонхны үйлчилгээ үзүүлэх төв"-д нийт 13 иргэний өргөдөл гомдлыг хүлээн авч харьяа прокурорын газарт нь шилжүүлж, 15 иргэнд прокурорын байгууллагын чиг үүрэг, үйл ажиллагаатай холбоотой зөвлөгөө

мэдээллийг өгч ажиллав.

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/2061